



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/554

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10 дугаар хуралдааны 10/06 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 98 дугаар тогтоолоор батлагдсан Төлөөлөгч хөтөлбөрийн санхүүжилтээс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэтгэлийн хуралдаан”-ы арга хэмжээний зардалд зарцуулах 26.8 сая төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Арга хэмжээнд зарцуулах 26.8 сая төгрөг /хорин зургаан сая найман зуун мянга/-ийг аймгийн Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний 5 дугаар заалтын 5.1 дэх заалтад тусгагдсан “Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг чадавхижуулах” төсөл, хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, “Хөшөөт хөгжил” сангийн захирал /Т.Мягмардорж/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

120

Аймгийн Засаг даргын 2020 оны
09 дүгээр сарын 28-ны өдрийн
А/554 дүгээр захирамжийн хавсралт

ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт өртөг
1	Төлөөлөгч, ажлын албаныханд олгох шаазан гадартай, логотой мөнгөн аяга	45	361000	16,245,000
2	Төлөөлөгч, ажлын албаныханд олгох домбо	7	350000	2,450,000
3	Төлөөлөгчдийн альбом	55	55000	3,025,000
4	Хүндэтгэлийн хуралдааны хүлээн авалтын зардал	65	50000	3,250,000
5	Бусад зардалд /урлагийн арга хэмжээ, шилдэг номинаци/	1	1800000	1,800,000
Нийт дүн				26,770,000

-oOo-